

# Сургуулиудад зориулсан COVID-н эсрэг ухаалаг арга хэмжээнүүд

## Гэр бүлүүдэд зориулсан мэдээлэл

Ангидаа бусадтайгаа хамт суралцах нь сурагчдын сурлага, өсөлт хөгжил болон нийгэмшихүйд эерэгээр нөлөө үзүүлдэг болохыг бид мэднэ. Энэ улиралд бид сурагчдынхаа сайн сайхан байдал, мөн тасралтгүй үргэлжилсэн, үр дүнтэй сургалтын орчинг бүрдүүлэхэд илүү анхааран, хэд хэдэн үргэлжилсэн арга хэмжээг авах болно.

### Биеийн байдал тавгүй бол гэртээ байх

- Хэрвээ таны хүүхдийн биеийн байдал тавгүй бол та тэднийг гэрт нь байлгах ёстой. Хэдийгээр тэдэнд илэрсэн COVID-19-н шинж тэмдгүүд хөнгөн байсан ч тэд COVID-н шинжилгээ өгөн, тусгаарлах ёстой.
- Таны хүүхэд шинжилгээний сөрөг хариу авсан, мөн шинж тэмдэг илрээгүй тохиолдолд л зөвхөн сургуульдаа буцан орж болно.
- Хэрвээ таны хүүхэд COVID-19-н шинжилгээгээр эерэг хариу авсан бол Service NSW-д эерэг хариу авснаа бүртгүүлэх ба 7 хоногийн турш тусгаарлан, NSW Health-н удирдамжийг мөрдөх ёстой.

### Дархлаажуулалт

- COVID-19 болон томуугийн дархлаажуулалт нь та өөрийгөө, гэр бүлээ, ард олноо хамгаалах хамгийн зөв арга юм. Дархлаажуулалт бол аливаа вирусын гаралтай өвчний эсрэг тэмцэхэд таны дархлааны системд дэмжлэг үзүүлдэг аюулгүй бөгөөд үр дүнтэй арга юм.
- Эрүүл мэндээ хамгаалахын тулд сургуулийн орчинд ажилладаг, шаардлага хангасан бүх ажилтнууд болон сурагчдыг дархлаажуулалтандаа бүрэн хамрагдахыг зөвлөж байна. COVID-19-д өртсөн тохиолдолд хүндээр өвчлөх өндөр эрсдэлтэй сурагчдыг хамгаалахын тулд тусгай хэрэгцээт сургуульд ажилладаг бүх ажилтнууд COVID-19-н эсрэг хоёр удаагийн дархлаажуулалтанд хамрагдсан байхыг шаардаж байгаа.

### Ойрын хавьтлууд

- Ойрын хавьтал болсон сурагчид энэ тухайгаа сургуульдаа мэдэгдэн, сургууль дээр ирэх эхний 5 өдрийн турш өглөө бүр COVID-19-н шинжилгээний сөрөг хариу авчрах нөхцөлтэйгээр сургуульдаа явж болно.
- Дунд сургуулийн сурагчид хооллох эсвэл дасгал хөдөлгөөн хийхээс бусад тохиолдолд дотор орчинд амны хаалт зүүх ёстой. Бага сургуулийн сурагчдад хооллох эсвэл дасгал хөдөлгөөн хийхээс бусад тохиолдолд дотор орчинд амны хаалт зүүхийг зөвлөж байгаа болно.
- Ойрын хавьтал болсон сурагчид хоногоор явах аялал эсвэл сургуулийн зуслан зэрэг өндөр эрсдэл бүхий арга хэмжээнд оролцохыг хориглоно.
- Тусгай хэрэгцээт сургууль болон дэмжлэг үзүүлэх тэнхимийн сурагчид ойрын хавьтал болсон тохиолдолд сургуульд явах боломжгүй ба өөрийгөө тусгаарлах хугацаанд алсын зайнаас суралцахад нь дэмжлэг үзүүлэх болно.

## Эсрэг биеийн түргэвчилсэн шинжилгээ

- Хэдийгээр таны хүүхдэд илэрч буй COVID-19-н шинж тэмдгүүд хөнгөн байсан ч, эсвэл ойрын хавьтал болсон бөгөөд сургуульдаа явж байгаа тохиолдолд өдөр бүр, эсрэг биеийн түргэвчилсэн шинжилгээг хийлгэх ёстой.
- Хэрвээ таны хүүхэд COVID-19-н шинжилгээгээр эерэг хариу авсан бол шинж тэмдэггүй болж, тусгаарлах хугацаа дуусах хүртэл сургуульдаа явж болохгүй. Эсрэг биеийн түргэвчилсэн шинжилгээний эерэг хариуг Service NSW-д бүртгүүлэх ёстой.
- Хэрвээ таны хүүхэд шинжилгээгээр сөрөг хариу авсан хэдий ч шинж тэмдэг илэрсэн хэвээр байвал шинж тэмдэггүй болтлоо сургуульдаа явж болохгүй.
- Сургуулиас 3-р улирлын эхэнд эсрэг биеийн түргэвчилсэн шинжилгээний 5 кит бүхий 1 багцыг сурагчид болон ажилтнуудад олгох болно. Тусгай хэрэгцээт сургууль болон дэмжлэг үзүүлэх тэнхимийн сурагчид болон ажилтнуудад эсрэг биеийн түргэвчилсэн шинжилгээний 5 кит бүхий 2 багцыг 3-р улирлын эхэнд сургуулиас нь олгох болно.
- Сургуулиуд дэгдэлт гарсан тохиолдолд тандалтын шинжилжилгээ авах зорилгоор ашиглах эсрэг биеийн түргэвчилсэн шинжилгээний хангамжийг нөөцлөх болно.

## Ариун цэвэр болон цэвэрлэгээ

- Сурагчдад тогтмол гараа савандаж, усаар угаах мөн шаардлагатай үед хувийн хамгаалах хэрэгсэл ашиглахыг зөвлөнө.
- Сургууль дээрх өдрийн нэмэлт цэвэрлэгээг хүний гар их хүрэлцдэг хэсгүүд, болон бусад хатуу гадаргуунууд, хаалганы бариул, цоож, гэрлийн унтраалга, шатны бариулууд болон хөдөлгөөн ихтэй хэсгүүдэд илүү төвлөрөн хийх болно.

## Агааржуулалт

- Халдвар дамжих эрсдлийг багасгах агааржуулалтын хамгийн үр дүнтэй арга бол цэвэр агаар юм.
- Хүйтний саруудад агаарын тэнцвэртэй байдлыг хадгалахын тулд агааржуулалтын аргыг халаагууртай хослуулан ашиглах болно.
- Улсын сургуулиудын сургалтын бүх орон зайд зохих түвшний агааржуулалт болон шаардлагатай агаар цэвэршүүлэгчээр хангагдсан эсэхийг хянан нягталсан.
- Аль болох гадаад орон зайг ашиглахыг үргэлжлүүлэн зөвлөнө.

## Амны хаалтууд

- Бүх сурагчид болон ажилтнуудыг үндсэн сургуулийн орчинд амны хаалтыг тогтмол бөгөөд ялангуяа дотор орчинд, агааржуулалтгүй бөгөөд зай барих боломжгүй бусад орчинд амны хаалт зүүхийг хатуу зөвлөнө.
- COVID-19-т өртсөн тохиолдолд хүндээр өвчлөх өндөр эрсдэлтэй сурагчидтай ажилладаг бүх ажилтнуудыг амны хаалт зүүхийг шаардана.
- Сургууль дээр ирсэн зочид ялангуяа сурагчидтай шууд харилцаа үүсгэх бол амны хаалт зүүхийг хатуу зөвлөх ба хэрвээ COVID-19-т өртсөн тохиолдолд хүндээр өвчлөх өндөр эрсдэлтэй сурагчидтай харилцаа үүсгэх бол амны хаалт заавал зүүхийг шаардана.
- Ойрын хавьтал болсон 7 болон түүнээс дээш ангийн сурагчдыг дотор орчинд амны хаалт зүүхийг шаардах ба үүнээс бага ангийн сурагчдад амны хаалт зүүхийг хатуу зөвлөнө.
- COVID-19-н халдвараар өвчилсөн бүх сурагчид эдгэрсний дараах 3 хоногт амны хаалт зүүхийг хатуу зөвлөнө.

## Зочид

- Зочид дархлаажуулалтын статусаас үл хамааран сургуулийн байр талбайд орж болно.
- Бүх зочидод ялангуяа дотор орчинд эсвэл зай барих боломжгүй газар, мөн сурагчидтай шууд харилцаа үүсгэх тохиолдолд амны хаалт зүүхийг хатуу зөвлөнө.
- Тусгай хэрэгцээт сургууль болон дэмжлэг үзүүлэх тэнхимд ирж буй ажилтнууд, сайн дурын ажилтнууд зэрэг зочид хэрвээ сурагчидтай шууд харилцаа үүсгэх тохиолдолд заавал амны хаалт зүүхийг шаардана.
- Сургууль дээр ирж буй ойрын хавьтал болсон зочид энэ тухайгаа сургуульд мэдэгдэн, дотор орчинд амны хаалт зүүх зэрэг тодорхой удирдамжийг мөрдөх ёстой. Тусгай хэрэгцээт сургууль дээр ойрын хавьтал болсон зочид орохыг хориглоно.

## Арга хэмжээнүүд

- Сургуулийн аялал, хоногоор явах зуслан зэрэг төлөвлөгөөт арга хэмжээнүүдэд эрүүл мэнд болон аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээнүүд хийгдэх болно.
- Эцэг эх, асран хамгаалагчдад аливаа эрсдлийг мэдэгдэх ба зарим арга хэмжээнд оролцоход зөвшөөрөл авах хэрэгтэй болно.

## Орон нутгийн тухайн нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах

- Вирусын өвчлөл дэгдэх зэрэг тухайн орон нутгийн нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ авахын тулд сургуулиуд Боловсролын яамны Эрүүл Мэнд, Аюулгүй Байдал болон Ажилтны Сайн Сайхан Байдал хариуцсан удирдлагын багтай хамтран ажиллах болно.
- Зарим тохиолдолд тухайн халдварын тархалтыг зогсоохын тулд сургуулиуд амны хаалт зүүхийг шаардах, шаардлагатай бус арга хэмжээнүүдийг хойшлуулах эсвэл багасгах, мөн тодорхой нэг бүлгийг алсын зайнаас суралцахад чиглүүлэх зэрэг түр хугацааны нэмэлт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

## Алсын зайнаас суралцах

- Алсын зайнаас суралцах шаардлагатай сурагчдад дэмжлэг үзүүлэх зорилгоор Боловсролын яам дижитал сургалтын материал боловсруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа.

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах вэб хуудсаар орж авна уу  
[education.nsw.gov.au/covid-19/advice-for-families](https://education.nsw.gov.au/covid-19/advice-for-families)

## Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ танд илүү дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгтэй бол сургуулийн захиралтай утсаар холбогдоно уу. Хэрвээ танд орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн хэл дээрх орчуулагчийг хүсээрэй. Операторт залгахыг хүссэн дугаараа хэлэхэд оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.

Сурагчид болон ажилтнуудын аюулгүй байдал, сайн сайхан байдлыг хангахын зэрэгцээ сургуулийн үйл ажиллагаа үргэлжлэн явагдаж байх тал дээр NSW мужийн Засгийн Газар хариуцлагатай үүрэг хүлээн ажиллаж байна.